МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 14 өдөр Дугаар А/280 Мандалговь

Отор нүүдлийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт "А" зэрэглэлийн "Шүлхий" өвчин Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан сумдад гарч өвчлөлийн голомт нэмэгдэж байгаа тул аймгийн хэмжээнд гаднаас мал отроор орж ирэх, гадагшаа отор нүүдэл хийхийг 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хориглосугай.

Хоёр. Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналт, хорио цээрийн дэглэмийг чангатгаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Захирамжийн биелэлтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүн, ажлын явцыг танилцуулж байхыг Онцгой комиссын орлогч дарга /Я.Алтанхундага/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0200786